



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/08.

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагуудыг магадлан итгэмжилсэн тайлан, цаашид авах арга хэмжээ" сэдэвт сургалтын ажлын удирдамж батлагдсан тул сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 22-нд зохион байгуулан явуулсугай.
2. Сургалтын бэлтгэл ажлыг ханган суурин эх үүсвэр ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүрэн хамруулж, сургалтын үр дүнг 2017 оны 05 дугаар сарын 26-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Х.Галымбек/-т даалгасугай.
3. Сургалт зохион байгуулахтай холбоотой ажлын зардал болох 510.000 /Таван зуун арван мянган / төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



М.ДЭЛГЭРЭХ